

Сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 19-ний
едрийн 36 дугаар тогтоолын хавсралт



СУМЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛ, ТӨЛӨВЛӨГӨӨ

НЭГ. ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД

Тогтвортой, хариуцлагатай төрийн албаны соёлыг төлөвшүүлж, хууль дээдэлсэн төрт ёсыг бэхжүүлэх, Шударга ёс, эрх тагш байдлыг эрхэмлэн хууль ёсыг дээдэлсэн чадварлаг, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хууль сахиулах үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зэрчмыг баримтална.

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Төсөв /сая/	Хөрөнгийн эх үүсвэр	Хугацаа	Хариуцах байгууллага
Нэг. Төрийн удирдлагын бодлого, Төрийн байгууллага, албан хаагчдын ёс зүй, ажлын хариуцлагыг өндөржүүлэн, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүнд сурталгүй болгож ажиллана.						
1.1.1	Сумын шилдэг "Төрийн албан хаагч" шалгаруулах журам боловсруулан батлуулж, хэрэгжүүлж эхэлнэ.	<ul style="list-style-type: none">✓ Сумын шилдэг "Төрийн албан хаагч" шалгаруулах журам боловсруулан батлуулсан байх✓ 2019 оны сумын шилдэг төрийн албан хаагчдыг шалгаруулж урамшуулсан байх	1,000,000	Орон нутгийн төсөв	2019 онд	ЗДТГ, Байгууллагууд

1.1.2	Иргэдэд шинээр гарсан хууль журмыг сурталчилан таниулах, сургалт, олон нийтийн ажил зохион байгуулах, гарын авлага ном бэлтгэж тараах	<ul style="list-style-type: none"> ✓ Иргэд хуулийн мэдлэг дээшлэнэ ✓ Шинээр гарч буй хууль, эрх зүйн мэдлэгийг цаг алдалгүй иргэдэд хүргэх ✓ Мэргэжилтэнүүд үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах 	10,000,000	ОНХС, төсөл хөтөлбөр	Жилдээ	ЗДТГ Мэргэжилтнүүд албан байгууллагууд, төсөл хөтөлбөр
1.1.3	Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нийтийн албаны үйл ажиллагааг иргэдэд хүнд сурталгүй, ил тод, алагчлалгүй, шуударга, хүртээмжтэй болгоно.	<ul style="list-style-type: none"> ✓ Авилгын эсрэг үйл ажиллагаа ил тод, нээлттэй болно ✓ Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухай бүр хянуулсан байх ✓ Ашиг сонирхлын зөрчлөө лэрхийлэх мэдэгдэл тайлбарыг тухай бүр гаргасан байх 		ОНХС, төсөл хөтөлбөр	Улирал тутам	ЗДТГ
1.1.4	Олон нийттэй харилцах үйлчилгээний хүрээг өргөжүүлж иргэдтэй уулзах уулзалтын арга хэлбэрийг хүртээмжтэй болгоно.	<ul style="list-style-type: none"> ✓ Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулана 			Тогтмол	ЗДТГ, Байгууллагын менежерүүд
1.1.5	Өрх бүрт Өрхийн Угийн бичгийн дэвтрийг тараан хөтлүүлэх, угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> ✓ Баг, байгууллагын дунд болзолт уралдаан зарлах ✓ Угийн бичгийн хөтлөлтийн хувь нэмэгдсэн байх 	2,000,000	Төсөл хөтөлбөр	Тогтмол	НБХМ, Соёлын төв, БЗД нар
1.1.6	Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй буку	<ul style="list-style-type: none"> ✓ Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр зөвлөгөөн зохион байгуулж, зохих шийдвэр гарсан байх. ✓ Согтуугаар үйлдэгдсэн гэмт 	1,000,000		Тухай бүр	Цагдаагийн хэсэг ГХУССЗ

	хууль бусаар худалдаж болох цэгүүдэд гэнэтийн хяналт, шалгалт хийх зэрэг арга хэмжээг явуулсанаар Архигүй баярын өдрүүдийг тэмдэглэдэг сум, хамт олон болно.	хэрэг, зөрчлийн тоо буурна.				
1.1.7	Сумын гэмшгээс хамгаалах үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах, Гэмшигээс хамгаалах бэлэн байдалд суралцах, үзүүлэх сургалт хийх.	✓ Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар			2, 3-р улиралд	ЗДТГ
<p>Хоёр. Эрүүл мэндийн байгууллагын холбогдох үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, тоног төхөөрөмжид шинэчлэл хийх, Боловсролын байгууллагуудыг хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд чиглүүлэх, багш нарын бүтээлч ажиллагааг дэмжиж, сургалт хүмүүжлийн ажлын уялдааг сайжруулна.</p>						
<p>2.1. Эрүүл мэндийн хүрээнд</p>						
2.1.1	ЭМТ-н барилгыг их засварт оруулах	ЭМТ-ийн барилга шинэчлэгдэн, чанаржсан байх.	350,000,000	Улсын төсөв	2019 онд	СЗД, ЭМТ-ийн дарга
2.1.2	Эрт илрүүлэг үзлэгийг 100% хийх	Хөх, Умайн хүзүү, АГТ, ЧШ, Элэг бүтэн монголын үзлэг шинжилгээ 100% хийгдсэн байх	1,000,000	Төсөл хөтөлбөр	2019 онд	ЭМТ-ийн дарга Лаборант, багийн эмч нар, БЗДарга нар
2.1.3	Сүрьеэгийн сорьц тээвэрлэх	Сүрьеэ эрт илэрсэн байх	300,000	Төсөл хөтөлбөр	2019 онд	Сүрьеэ хариуцсан мэргэжилтэн, сайн дурын идэвхитэн

2.1.4	Багийн эмч нарыг унаатай болгох	Багийн эргэлтээр явахад болон дуудлаганд явахад түргэн шуурхай болох	6.000.000	Эрүүл мэндийн яам	2019 онд	СЗД, ЭМТ-ийн дарга
2.1.5	Биохимийн аппараттай болох	СЭМТ-өө шинжилгээг авдаг болох	8.000.000	ОНХС	Жилдээ	ЗД, ЭМТ-ийн эрхлэгч
2.2 Боловсролын байгууллагын хүрээнд						
2.2.1	Сургуулийн барилгын их засварын зураг төсвийг хийлгэх	<ul style="list-style-type: none"> ✓ Сургуулийн дулаан алдагдалт арилана ✓ Гадна өнгө үзэмж сайжирч, аюулгүй байдал хангагдана 	300.000.000	Улсын төсөв	2019 онд	Засаг дарга, ЕБС-ийн захирал
2.2.2	Дотуур байрыг их засварт оруулах зураг төсвийг хийлгэх	<ul style="list-style-type: none"> ✓ Тус байранд төрийн албан хаагчид ая тухтай орчинд аюулгүй амьдрах нөхцөл бүрдэнэ.Суманд шинээр ирж буй боловсон хүчнийг орон байраар хангадаг. 	420.000.000	Улсын төсөв	2019 онд	Засаг дарга ЕБС-ийн захирал
2.2.3	Цэцэрлэгийн хичээлийн байрыг их засварт оруулах	<ul style="list-style-type: none"> ✓ Зураг төсвийг гаргасан байх ✓ МХ-дүгнэлт гарсан байх 	289,427,537	Улсын төсөв	2019-2020 онд	Аймгийн Засаг дарга, БСУГ
2.2.4	Цэцэрлэгийн багш нарын ширээ сандлыг шинэчлэх	<ul style="list-style-type: none"> ✓ Багш нарын ажиллах орчин бүрдэнэ. ✓ Багш хөгжлийн төвийн өнгө үзэмж сайжирна. 	1.000,000	ОНХС	2019 онд	Цэцэрлэгийн эрхлэгч ЗДТГ
2.2.5	Хамтарсан багийн ажлыг чанаржуулж ажиллах	<ul style="list-style-type: none"> ✓ Хамтарсан багийн үйл ажиллагаа сайжирна 	500,000	Улсын төсөв	Сар, улирал, жилээр	Хамтарсан баг, БАХ-ын хэсгийн ахлагч нар
2.3. Соёл урлагийн хүрээнд						
2.3.1	Соёлын төвийн шинэ барилгатай болох	<ul style="list-style-type: none"> ✓ 2019 онд шинэ соёлын төвийг бариулж дуусган соёлын үйл ажиллагаанд ахиц гаргах 	1.261.000.000	Улсын төсөв	2019 онд	Соёлын төв Засаг дарга

2.3.2	Морин хуур, уртын дууны сургагч багш нарыг бэлтгэн, сургалт явуулж, морин хуур, уртын дууны хамтлаг, чуулга байгуулан, дуу хуураа өвлүүлэн хөгжүүлнэ.	✓ Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны дагуу 3000 морин хуурч, 3000 уртын дуучдын наадамд авъяастнуудаа бэлтгэл сайтай оролцуулж хөгжим, урлагийн хувцасаар ханган ажиллаж "Дуу хуурын Өлгий" нэрээ хамгаалж үлдэх	2.000.000	Төсөл хөтөлбөр	2019 онд	БСУГ, ТХДЖТ, ТТХТ, Сумдын Засаг дарга
2.3.3	Нутгийн алдартан, гавьяатнуудын нэрэмжит уралдаан, наадмыг зохион байгуулж, тэдний уран бүтээлийг залгамж хойч үедээ өвлүүлэн уламжлуулна.	✓ Сумын "Өлзийт түмний ая дуу" урлагийн наадмыг 2 жил тутамд зохион байгуулж соёлын өвийг дэмжигчид авъяаслаг залуучуудыг төрүүлж гаргах, алдаршуулах	2.000.000	Нутгийн зөвлөл, төсөл хөтөлбөр	2019 онд	Соёлын төв ЗДТГ, Багийн Засаг дарга нар
Гурав. Дэд бүтэц, Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, Байгаль орчин Сумын мал эмнэлэг, үржлийн тасгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Төрөөс малчдад үзүүлэх үйлчилгээг сайжруулна.						
3.1. Дэд бүтцийн ажлын хүрээнд хийгдэх бүтээн байгуулалт						
3.1.1	Буянтын 1,2-р багийн соёлын төвийг засварлах хийлгэх	✓ Багийн иргэдийн соёлын үйлчилгээг авна	160.000.000	ОНХС	Жилдээ	БЗД нар
3.1.2	Сумын төвийн гэр хороололыг цэгцэлж жигдрүүлэх (А зэрэглэлийн бүс)	✓ Сумын төвийн өнгө үзэмж сайжирна ✓ Эмх цэгцэнд орно		Өвөрсдийн хөрөнгө	Жилдээ	ИТХ, ЗДТГ, БЗД нар, иргэд
3.1.3	Хуурай сүүний үйлдвэрийн	✓ Үйлдвэр баригдаж ажиллах	64.000.000	Орон	Жилдээ	ЗД

	барилга барьж үйлдвэрийг ашиглалтанд оруулах			нутгийн төсөв		
3.1.4	Цаг уурын шинжилгээний торон хашааг томсгох	✓ Цаг уурын тоног төхөөрөмжийн хамгаалалтай сайн болно	3,000,000	Орон нутгийн төсөв	Жилдээ	ЗД
3.2. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд						
3.2.1	Баг бүрт энгийн уурхайн худаг засварлана	✓ Хүн, мал усаар хангагдана ✓ Малчидын төвлөрөл, малын бөөгнөрөл багасна	48,000,000		Жилдээ	ЗДТГ, БЗД нар
3.2.2	Рашаантын аманд гүн өрмийн худаг гаргах	✓ Ундны усны чанар сайжирна ✓ Ногоон байгууламжийн усалгааг хангаж шугам хоолойг татах	19,800,000		жилдээ	Засаг дарга, БЗДарга
3.2.3	Хилийн цэс тогтоогоогүй үлдсэн газар нутгуудыг тогтоох /Хойд хэсгээр/	✓ Хөрш зэргэлдээ сумдын малчдын хилийн маргаан багасна ✓ Үлдсэн газрын маршрут гаргаж, явах км-ыг тооцсон байх	1,000,000	БОХСан	Жилдээ	ЗД,БХ, Газрын даамал,БЗД
3.2.4	Сумын нутаг дэвсгэрт орших түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг аймаг сумын хамгаалалтанд авахуулан хадгалалт хамгаалалтыг сайжруулна.	✓ Кадастрын зураг хийлгэх	500,000	БОХСан	Хөтөлбөрийн хүрээнд	БЗД нар, Газрын даамал, БОБайцаагч, Соёлын төвийн эрхлэгч
3.2.5	Кадастрт ороогүй үлдсэн эзэмшил, өмчлөлийг кадастрт оруулах /өвөлжөө, хаваржаа/	✓ Кадастрт ороогүй нийт өрхийн тоог гаргаж, явах км-ыг тооцсон байх	800,000	ОНХС	2019 онд	БЗД нар, Газрын даамал

3.2.6	Бэлчээрийн газрын верчлэлтийг фотомониторингийн аргаар үнэлэх	<ul style="list-style-type: none"> ✓ Судалгаа хийх цэгүүд тодорхой байх ✓ Судалгаа хийх цэгүүд хоорондын км-ыг тооцож, маршрут гаргасан байх 	900.000	Орон нутгийн төсөв	Жил бүр	Газрын даамал
3.2.7	Стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 10 дугаар сарын 27-ны едрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан Нэгдсэн хаягжуулалт	<ul style="list-style-type: none"> ✓ Хаягийг стандартын дагуу үнэн зөв тогтоох 	5.764.200	ОНХС	2019 онд	Засаг дарга, Газрын даамал
3.2.8	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг иргэдэд суртчилан таниулах	<ul style="list-style-type: none"> ✓ Иргэд олон нийтэд нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг таниулах тухай үйл ажиллагаа зохион байгуулах ✓ Судлагаа хийх ✓ Иргэдээс санал авах 	9.000.000	ОНХС	2019 онд	БЗД нар, Газрын даамал
3.3. Сумын мал эмнэлэг, үржлийн тасгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Төрөөс малчдад үзүүлэх үйлчилгээг сайжруулна.						
3.3.1	Малчдыг малжуулах, хашир туршлагатай малчдыг дагалдуулан сургах, зээл болон бусад төсөл хөтөлбөрт хамруулах замаар малчдын залуу халааг бэлтгэх халамжийн төсөл хөтөлбөрт хамруулах	<ul style="list-style-type: none"> ✓ Малчдыг Халамжийн малжуулах төсөл болон ОНХСангийн хөрөнгөөр малжуулахад хамруулсан байх ✓ Залуу малчдын сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран тодорхой үе шаттай зохион байгуулсан байх 	20.000.000	Төсөл, хөтөлбөр	Тухай бүр	ЗДТГ, БЗДнар, малчид

3.3.2	Багийн онцлогт тохируулан өдөрлөгийг зохион байгуулж иргэдийн санал хүсэлтийг сонсох, цаашид авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнг тооцно.	Малчид цаг үеийн мэдээ мэдээлэлээр хангагдсан байх	500.000	Орон нутгийн төсөв	2-р улиралд	ЗД-ын орлогч, ЗДТГ-ын дарга, БЗД нар
3.3.3	"Говийн тэмээ - 2019" тэмээчдийн өдөрлөгт малчдыг хамруулж оролцуулах	<ul style="list-style-type: none"> ✓ Тэмээний тоо өснө ✓ Тэмээг уналага, эдэлгээнд хэрэглэх, бүтээгдэхүүний тоо нэмэгдэх ✓ Оролцогчдын тоо нэмэгдсэн байх 	1.000.000	Орон нутгийн төсөв	1-рулирал	ЗДТГ, БЗД нар байгууллагууд
3.3.4	Сумын өвс тэжээлийн нөөцөлж эргэлтийн санг нэмэгдүүлнэ.	Нөөц бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх	5.000.000	Орон нутгийн төсөв	4-р улиралд	ЗДТГазар
3.3.5	Сум хөгжүүлэх сангийн зээлийг оновчтой зохион байгуулах, үйлдвэр үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> ✓ Үйлдвэр үйлчилгээ, ажлын байрны тоо нэмэгдсэн байна ✓ Өмнөх онуудад олгосон хугацаа хэтрэлттэй зээлийн өрийг барагдуулсан байна. 	50.000.000	Сум хөгжүүлэх сан	Жилдээ	ИТХ, Засаг дарга
3.3.6	Зал авахыг хүссэн иргэдийг Бизнесээ эхэл - Бизнесээ хөгжүүлэх сургалтанд хамруулж бусад аймаг сумдын үйлдвэрүүдийн тэргүүн туршлагыг судлах, үзэсгэлэн худалдаанд оролцуулах	<ul style="list-style-type: none"> ✓ Бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдсэн байх ✓ Сумын брэнд бүтээгдэхүүнтэй болох ✓ Үзэсгэлэн худалдаанд оролцогчдын тоо нэмэгдсэн байх 	1.000.000	Сум хөгжүүлэх сан	1-р улиралд	ЗДТГ, ХАА-н тасаг, БЗДарга нар

3.3.7	Сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтний техник тоног төхөөрөмжийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> ✓ Сум хөгжүүлэх сангийн програмтай болж шинэ нэгтбүхээр хангагдсан байна. ✓ Бүх зээлдэгчдийн хувийн хэрэгийг шинэчилсэн байна. 	2.000.000	Сум хөгжүүлэх сан	Жилдээ	ЗДТГ
3.3.8	Мал эмнэлгийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж дэмжиж ажиллах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, бусад үйлчилгээнд цаг тухай бүрд нь бүрэн хамруулна.	Мал сүргийг дархлаажуулалтанд бүрэн хамруулсан байна.		Улсын төсөв	2-р улирал	МЗУНэгж
Дөрөв. Байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхай						
4.1 Байгаль орчны чиглэлээр						
4.1.1	Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөө, энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, устгах, булшлах журмийн хэрэгжилтийг хангах	<ul style="list-style-type: none"> ✓ Сумын ИТХурлаар хог хаягдлын хураамжийг шинэчлэн батлуулах ✓ Сумын газар нутагт үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг иргэн, ААН, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудтай хог хаягдлын гэрээ байгуулж ажиллах ✓ Орон нутгийн хог хаягдлаас орох орлого биелүүлэх ✓ Сумын төвийн хог ачих үйлчилгээг тогтмолжуулах, 	2.000.000	БОХС	Жилдээ	БОХУБ БЗД

		орчны болон нийтийн цэвэрлэгээг тухай бүрт чанартай гүйцэтгэсэн байх				
4.1.2	Хүүхдүүдэд хог хаягдал, усны ашиглалт хамгаалалтын талаар цогц ойлголт өгөх, ЕБС, СӨБ-д хичээлийн програмд суулгаж өгөх, ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж самбар байрлуулах	<ul style="list-style-type: none"> ✓ Сурагчдын хог хаягдал болон усны ашиглалт хамгаалалтын тухай мэдлэг сайжирсан байх ✓ Байгаль орчинтой холбогдолтой сургалт сурталчилгаа зохион байгуулсан байх 	500.000	БОХС	Жилдээ	БОХУБ ЕБС Цэцэрлэг Байгаль хамгаалагч
4.1.3	Жил бүрийн бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх	<ul style="list-style-type: none"> ✓ Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тэмдэглэн сумын ногоон байгууламжид шинээр мод тарих, нөхөн тарилт хийх, модны арчилгаа усалгааг хийсэн байх 	3.000.000	БОХС	5,10-р сард	БОХУБ Байгаль хамгаалагч
4.1.4	Ан амьтан хамгаалах чиглэлээр эргүүл хийх, хяналт тавих	<ul style="list-style-type: none"> ✓ Ан амьтны агнуурын үеүүдэд болон хяналт шалгалт хийх зөрчилгүй ажиллах ✓ Ан амьтантай холбоотой зөрчил үүссэн тохиолдолд тухай бүрт хяналт шалгалтыг хийж зөрчлийг таслан зогсоох 	1.000.000	БОХС	Жилдээ	БОХУБ Байгаль хамгаалагч Цагдаагийн хэсэг
4.1.5	Заган ойг хамгаалах чиглэлээр эргүүл хийх, хяналт тавих	<ul style="list-style-type: none"> ✓ Өвөлжилтийн бэлтгэл хангах үед хадлан хадахад түүнд ховор, нэн ховор ургамалын зүйл өртөх буюу түүнтэй холбогдолтой зөрчилгүй ажиллах 	1.000.000	БОХС	3, 4-р улиралд	БОХУБ Байгаль хамгаалагч Цагдаагийн хэсэг

		<ul style="list-style-type: none"> ✓ Заган ойг хамгаалах зорилгоор загын байршил бүсүүдэд түлшний мод бэлтгэлийн үед хяналт шалгалт хийж байнгын эргүүл тойруулыг хийх ✓ Заган ой болон ховор, нэн ховор ургамалтай холбогдолтой зөрчил үүссэн тохиолдолд тухай бүрт зөрчлийг таслан зогсоох 				
4.2 Аялал жуулчлалын чиглэлээр						
4.2.1	Аялал жуулчлалын үзмэр бүхий газар нутагт үйлчилгээний төлбөр хураамж тасалдаг болох	<ul style="list-style-type: none"> ✓ Сумын ИТХурлаар аялал жуулчлалын үйлчилгээний хураамжийг төрөл тус бүрээр тогтоож батлуулах ✓ Аялал жуулчлалын улиралд Байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч нарыг идэвхжүүлж тасалбэр тасалдаг болох ✓ Аялал жуулчлалын бүс нутгийн орчны цэвэрлэгээг сайжруулах 	3.000.000	БОХС	2,3-р улиралд	БОХУБ Байгаль хамгаалагч Идэвхтэн байгаль хамгаалагч Баазууд
4.2.2	Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөжүүлэх	<ul style="list-style-type: none"> ✓ Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлж гадаадын болон дотоодын зорин ирэх жуулчны тоог нэмэгдүүлэх ✓ Адуу, айраг, тэмээний баяр, соёл, урлагийн болон зан заншлын бусад арга хэмжээ зохион байгуулагдсан байна 	5.000.000	Орон нутгийн төсөв	1,3-р улиралд	ЗД БЗД БОХУБ Байгаль хамгаалагч Баазууд ЖДҮ, ХАА

4.3 Ашигт малтмал, уул уурхайн чиглэлээр						
4.3.1	Ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс орон нутагт төлсөн татвар, төлбөр, торгууль, хандивыг ил тод мэдээлнэ	<ul style="list-style-type: none"> ✓ Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулсан байх ✓ Олборлолт, орлогын хэмжээ нэмэгдэж, иргэд олон нийтэд ил тод болсон байх 	1,500,000	БОХС	1-р улиралд	ИТХ ЗДО БОХУБ БЗД Лиценз Эзэмшигчид
4.3.2	Хариуцлагатай уул уурхай явуулагч бусад аймаг сумдаас туршлага судлах, тэдгээрийн сайн жишгийг өөрийн суманд нэвтрүүлэх	<ul style="list-style-type: none"> ✓ Өөрийн болон бусад аймаг, сумдын дэд зөвлөлөөс туршлага судлах тэдний арга аргачлалыг сумандаа нэвтрүүлэх хариуцлагатсай уул уулхайг бий болгох 	1,000,000	БОХС	Жилдээ	ИТХ ЗДО БОХУБ БЗД
4.3.3	Уул уурхай, бичил уурхайн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулахад хяналт тавьж, хууль эрхзүйн сургалт сурталчилгааг зохион байгуулна	<ul style="list-style-type: none"> ✓ Хяналт шалгалтыг удирдамжийн дагуу хийх, зөрчлийг арилгуулсан байх, зөрчил буурч, эрсдлийн үнэлгээ өссөн байх ✓ Сургалт, сурталчилгаа, зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулсан байх 	1,500,000	Бичил уурхайг дэмжих сан	Жилдээ	ИТХ, ЗДО, БЗД.
Тав. Санхүү, эдийн засгийн бодлого Төсвийн сахилга батыг чанд баримтлан ажиллана.						
5.1.1	Төрийн сангийн төлбөр тооцооны журмыг бүрэн хэрэгжүүлж, үйлчилгээний шуурхай байдлыг хангах	ЗГУМСийн үйл ажиллагаа хэвийн явагдсан байх			тогтмол	Санхүүгийн албаны дарга
5.1.2	Татварын дутагдалтай	Орлогын төлөвлөгөө биелэгдсэн			Тогтмол	ЗДТГ, Улсын

	байгаа орлогыг нэмэгдүүлэх	байх			байцаагч нар. Цагдаагийн хэсэг, БЗД нар
5.1.3	ОНХСангаар хэрэгжиж буй ажлуудыг нээлттэй ил тод хэрэгжүүлэх, бүрдэлтийг сайжруулах				Тогтмол ЗДТГ
5.1.4	Төрийн төсвийн гарч буй шийдвэрийг Шилэн дансны хуулийн дагуу ил тод нээлттэй байлгаж ажиллана.	6 төсвийн байгууллага, 1 ОНӨҮГ нийт 7 байгууллагын төсөв санхүүгийн мэдээллийг сайтад байршуулсан байх			Сар улирал хагас бүтэн жил Санхүүгийн албаны дарга

Бүлэг-5 Заалт-56

НЭГТГЭСЭН: НБХМ
ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА



Б.ОЮУНХАНД
А.ЭРДЭНЗБАТ